

**Хорчины орон сууцны соёлын  
эх сурвалжийг шинжлэх нь**

**Бай Ган (БНХАУ)**  
*Өвөр Монголын үндэсний их сургууль*

"Хорчины язгуурын тулгар өвөг" Хавт Хасарын уугуул нутаг нь "Монголын өндөрлөгийн зүүн хойд хавийн Эргүнэ гол, Хөлөн нуур, Хайлаар гол дагуу орон болно"<sup>1</sup>. Гэвч тухайн нийгэм түүхийн улирал хөгжилтэй зохицолдон XV зууны тэргүүн хагасад "Хадай хааны дагуулгаар Хөлөнбуйрын нутгаас анх удаа Нон мөрний урсгал дагуу оронд нүүдэллэн суурьшиж Нон хорчин гэх нэршил анх бий болсон"<sup>2</sup> ба Хорчин гэх нэр нь нэгэнт аймгийн нэршилээр түүх сударт тэмдэглэгдэх болжээ.

Хожим нь 16-р зууны дунджаар Гүймөнх Тасгарын дагуулгаар "Нон мөрний урсгал дагуу орноос урагш нүүдэллэж, Мин улсын Ляо Дунгийн хязгаар, дээд Шар мөрний урсгал дагуу оронд суурьшив"<sup>3</sup>. Ийнхүү Хорчинчууд нь Монголын өндөрлөгөөс дээд Шар мөрний урсгал дагуу орон хүртэлх өргөн уудам нутагт хэдэн удаа нүүдэллэн суурьшихдаа "Монголын улс төрийн төвөөс зайтай оршсон зэрэг улс төр, аж ахуй, газар зүйн нөхцөл шалтгаанаар Монголын их хаантай харьцаа суларсан"<sup>4</sup> боловч эсгий туургат монгол гэртээ сууж, таван хошуу малаа маллан амьдарч байжээ. Ийм болохоор бид Хорчины орон сууцны соёлын эх сурвалжийг хайн шинжлэхдээ юуны өмнө монголчуудын газар нутгийн тухай үзэл ойлголтоос эхэлж өгүүлбэл зохино.

**1. Монголчуудын газар нутгийн тухай үзэл ба эзэмших арга**

Газар нутаг (ус бэлчээр)-ийг эзэмших зурлага ба арга нь гэрээр амьдрах болсон үеэс нааших хүмүүсийн орон гэрийн хийц бүтэц, амьдралын хэвшлийг тогтоох гол үндэслэл болсон байдаг. Үүнд: нүүдлийн амьдралын нутаг бэлчээрийг улирлыг даган зохих хугацаанд сунган эзэмшихээр зорин өрнөдөг байхад суурьшил амьдрал нь газар шороог урт хугацаанд (тогтмол) өмчлөн эзэгнэдэг зүй тогтолтой байдаг.

Монголчуудын газар нутгийн тухай үзэл ойлголт, эзэмшилийн бүхий л явцыг "нутаг" буюу "нүүдэл" гэх хоёрхон үгээр тодорхойлон хэлж

болно. Учир нь монгол угсаатны хувьд авч хэлбэл "нутаг" хэмээн тэдний аж амьдралын газар шороог, "нүүдэл" гэж түүнийг (газар шороо) ашиглах арга хэлбэрийг заадаг байжээ. Ийм болохоор "нутаг" ба "нүүдэл" хоёр нь нүүдэлчин монголчуудын бүхий л амьдрал үйлдвэрлэлийн хамгийн тодорхой дүр төрх нь болж байжээ.

Эргэх дөрвөн улирлын туршид үргэлж эх газрын уур амьсгалын бүсэд оршдог монголын өндөрлөгийн (монголчуудын) малжилын үйлдвэрлэлд хамгийн тодорхой шийдвэрлэх үйлдэл бүхий улирал бол өвөл, зуны хоёр улирал мөн. Ийм болохоор монголчууд он жилийн гортиг хүрээнд дахин давтагдах шинжтэй явагддаг цаг улирлын эрхшээл бүхий "сэргэлт", "бууралт"-ын хоёр чиглэл хандлагад зохицуулж, өвөл хаврын "бууралт"-ын үед мал сүргээ онд мэнд оруулах, зун, намрын "сэргэлт"-ийн үед аль болохоор сайн тарга хүч авахуулахад тэдний хамаг үйл ажиллагааны гол зорилт оршдог мөртөө тэрхүү зорилгыг биелүүлэхэд нь сонгон эрхшээсэн нутаг нь шийдвэрлэх үйлдэл үзүүлдэг байжээ.

Ийм учраас монголын нийгмийн эдийн засгийн харилцааны үндсийг газар (нутаг), мал хоёрын бодит холбооны нэгдэлд авч үзэх нь зүйтэй. Онцгойлон монголчууд ангит нийгэмд орсны сүүлээрх үйлдвэрлэлийн харилцааны үндэс нь газар ба мал болсон байдаг. Гэвч газар нь тэргүүн зэргийн шийдвэрлэх хүчин болж, мал нь түүний хавсралт дагалт чанартай байсныг тэмдэглүүштэй. Тухайлбал монгол оронд мал нь нэг талаар үйлдвэрлэлийн хэрэгслийн үүрэгтэй, нөгөө талаар хөдөлмөрийн бүтээгдэхүүний шинжтэй давхар үүрэг гүйцэтгэж байдаг. Малыг уналга, тээвэр, ажлын хүч болгож хэрэглэхээс гадна орон бууц, хувцас хунар, хүнс тэжээл, эд таваарын чиглэлээр ашиглаж нийгмийн бүтээгдэхүүний хуваарилалтад оруулж байв.

"Монголын нууц товчоо"-нд "Нуган хөвгүүн минь нутаг харьюу, охин хөвгүүн минь өнгө үзэгдюү" гэж тэмдэглэсэн нь монголын овгийн нийгэмд хөвгүүн үрс (эрэгтэй хүүхэд) эцгийн нутгаа эзэмшин сууж, охин үр (эмэгтэй хүүхэд) харь овогт харьлан очдог, онцгойлон газар нутаг бол эрчүүд буюу "нуган хөвгүүд"-ийн үе улирах эзэмшлийн зүйл гэж үздэг эцэгчлэлийн нийгэмд орсны сүүлээрх хүмүүсийн амьдрах үзлийнх нь тод тусгал байжээ.

Нүүдлийн мал аж ахуйн өвөрмөц онцлогоос болж монголчууд тогтмол нэг нутагт (буюу өтөг бууцад) жилийн туршид байнга нутаглах бололцоогүй байдаг. Цаг улирал ба өвс билчээрийн аяс байдлыг харгалзан тодорхой хэмжээний дэвсгэр газарт нүүдэллэдэг ёстойгоос монгол хүний "нутаг" гэх ойлголтод "билчээр" гэх ухагдахуун хамаарагдах нь зайлшгүй хандлагатай байжээ. Ийм болохоор монголчууд газар нутгийн тухай ер нь "нутаг билчээр", "билчээр нутаг" гэхчилэн хоршин хэлцэх зуршилтай болсон байдаг.

Рашид-ад-дин Татарын тухай "Тэд далан мянган гэр өрх бий. Хятад орны хязгаарт ойр, овог салбараараа тусдаа нутаг ус эзэмшиж суумой. Үлэмжхэн эрхшээсэн юрт-нутаг нь Буйр нуур нэрт газар бөлгөө" хэмээн тэмдэглэсэн бол Юан улсын судрын адууны засгийн тэмдэглэлд монгол аймгуудыг "Зунаас өвөл болтол газрын сайныг шилж, өвс усыг даган нүүдэллэмой. 10-р сарын үед тус тусын уул нутагт буцмой"<sup>5</sup> гэж дурссан байдаг. Энд уул нутаг гэж өвөлжөөний нутгийг хэлсэн бололтой.

Нүүдэл бол нүүдэлчин малчдын амь нас мөн. "Нутаг билчээрийг хуваах, тус тусын мал сүрэг буюу аймаг бүлгийнхээ жил жилийн отор

нүүдэлд зохих зай талбай гаргаж өгөх дадал аль эртээс түрэг аймгийн дунд байжээ”<sup>6</sup>.

Ер нь монгол гэрээр амьдардаг малчид нэг газар дээр тогтвортой удаан суудаггүй, тэдний хамгийн удаан суудаг газар гэвэл өвөлжөө болно. “Гэхдээ хамгийн уртдаа дөрвөн сар суух бөгөөд их төлөв 200 хавтгай дөрвөлжин метр газрыг хэрэглэхийн төдий” юм.

Тэр тутамдаа монголчуудын малжилын амьдрал нь тариалангийн үндэстнийх шиг тогтсон газарт хадан суурьших буюу бусдыг гадуурхах тохиолдолгүй, харилцан нутаг булаалдах, түрэмгийлэх мэтийн үзэгдэл гарахгүй, харин хэд хэдэн айл хаяа нийлэн бууж хүч хамтатган ажилладаг нь зөндөө. Ийм болохоор өвөлжөөгөө “хувь хүн жил жил хэрэглэдэг, өвөлжөөнөөсөө нүүсэн ч аргал зэргээ үлдээх нь ердийн үзэгдэл болно. Хашаа саравч зэргээ нүүхээсээ өмнө түлш болгон шатаах болохоор олонхи байдалд үл үлдэнэ. Энд юу ч үлдэхгүй боловч дараа жил нь мөн тэр хүн ирж эзэмших хэрэг юм. Тэр билчээрт өөр хүн урьдаар буусан ч дураараа хүний өвөлжөөний бууцан дээр эзэн суух биш юм”<sup>7</sup>.

Ийнхүү монголчуудад авч хэлбэл өвөлжөөний нутаг нь харьцангуйгаар нэлээд урт хугацаанд амьдрах суурьшил нутаг нь болдгоороо хаваржаа, зуслан, намаржааны нутгаас нэн илүү эрхэмлэгдэх учиртай байжээ. Тухайлбал хахир хатуу өвлийн улирлын шалгалтыг аргалан давж малаа мэнд оруулж дийлэх эсэх нь өвөлжөөний нутгаас голцуу шалтгаална. Ийм болохоор малчдын нүүдлийн амьдралд туйлын гүн гүнзгий ач холбогдолтой байдаг өвөлжөөний нутаг нь монголчуудын нүүдэл малжилаас суурьшил малжил тийш хөгжин шилжихэд нь нэг ёсны анхных нь гараа болж өгчээ.

Холбогдол бүхий түүх шастираас үзвэл монголчууд хүй нэгдлийн үед “хүрээ”, овгийн задрал буюу боолт нийгмийн үед “айл”, феодал нийгмийн үед “хот” хэмээх нийгэм аж ахуй, хөдөлмөрийн зохион байгуулалтын хэлбэрээр нүүдэллэн амьдарч байжээ.

13-р зууны үед монголын хаант улс байгуулагдаж, монголын харъяат нутаг нь монгол хаад ноёдын (алтан урагтан) “Их уураг нутаг”, түмт мянгатын ноёдын “эзэмшил нутаг” жич талын язгууртнуудын “дархалсан нутаг” гэх газар нутгийн өмчлөлийн үндсэн гурван хэлбэр ноёрхож, урьдын овог аймгийн үеийн “нутаг”-ийн тухай ойлголт нь улс гүрний шинж чанартай болж, улсын хаад ноёдоос “нутаг”-ийн хэргийг эрхлэн шийдвэрлэх болжээ.

Хожим нь XIV-XVI зууны үе болоод монгол орны газар өмчлөлийн хамгийн үндсэн нэгж нь “аймаг” (аймак), “отог” (оток) хоёр болжээ. “Аймгийн нутаг нь тухайн аймгийн эдийн засгийн үндэс-мал аж ахуйн үйлдвэрлэл явуулах материаллаг нөхцөл хангахын зэрэгцээ түүний оршин тогтнох, захиран баримтлах явдлын гол баталгаа болж байв”<sup>8</sup>.

Ийм болохоор тухайн үеийн хүмүүс нь ямар ч нөхцөл ба цаг үед ч гэсэн уул аймгийнхаа хязгаар нутагт оршин суух ёстой бөгөөд түүнээс давж гарахыг хуулиар хориглодог байжээ. Үүнийг бид олон зууны туршид нүүдлээр амьдарч ирсэн монголчуудын суурьшил малжилын амьдрал тийш замнаж эхэлсэн анхны аялал гэж болно. Учир нь 15-17-р зууны тэргүүн хагасын монгол орон нь үнэндээ “аймгийн тогтолцоонд түшиглэж

түүний оршин тогтнох эдийн засгийн хүчин зүйл нь газар нутгийн харъяалал байжээ"<sup>9</sup>.

17-р зууны үед монголчууд Манжийн харъяанд орж монгол хүмүүсийн газар нутгийн ойлголтод шинэ тогтолцоо бий болж, монголын газар нутгийн хамгийн дээд эзэмшигч нь цорын ганц манж хаан болжээ. Манжийн хаадаас монголчуудын мундаг их баатар хүчийг бууруулан ашиглахын төлөө монгол оронд "Хошуу чуулганы дүрэм"-ийг хэрэгжүүлснээс 14-16-р зууны үеийн "аймаг", "отог" нь доройтон устаж манжийн хошууд болон хувирчээ.

Манжийн үеийн монгол хошуу чуулганы дүрмийн мөн чанар, зорилгыг Чин улсын Эеэр засагчийн 5-р онд буулгасан зарлигаас тодорхой мэдэж болно. "Хилийн цаадах монгол газрыг дээслэн хэмжиж, тус тусын эзэмшил газарт нь зааг шугам тогтоон өгч, түүгээр давахыг зөвшөөрөхгүй"<sup>10</sup> гэж тэрхүү зарлигт дурдсан байдаг.

Манжийн ноёрхлын үеийн хошуу нутгийн өмч хуваарилалтын байдлаас үзвэл, нэгд, Манж улс буюу эзэн хааны тухайлсан өмч нутаг, хоёрт, засаг ноёд түүний дагалдагсад, хүрээ хийд, хутагт хувилгаадын эзэмшил нутаг, гуравт, ард олны нийтийн эдэлгээний нутаг гэж хэдэн хэсэгт хуваагдаж байжээ. Онцгойлон ард олны нийтийн эдэлгээний нутгийн хил хязгаар нь тухайн хошууны цар хэмжээгээр тогтоогддог учир монгол орны малчин түмэн манжийн хааны зарлиг ёсоор ганц нэг хошуу нутгийнхаа явцуу хүрээнд хүлэгдэн амьдрах хэрэгтэй болжээ. "Ямар ч ард атугай харъяат нутаг буюу тайжийн албат хамжлага байж, түүний хошуу отог сумын нутгийн хүрээний тодорхой нэгэн хэмжээт газар усанд хүлэгдсэн мэт нутаглан сууж байв".

Ийнхүү монголчуудын нүүдэл буудлын зохион байгуулалтын хэлбэрт "хүрээ", "айл", "хот", "аймаг", "отог" мэтийн үндсэн хэдэн загвар оршиж байсан мөртөө тэр нь 17-р зуун болтлох (монголчууд манжид эзлэгдэх хүртэлх) монгол угсаатнуудын газар (нутаг билчээр) эзэмшлийн үндсэн арга хэлбэр, шинж төрх болж байжээ.

Монголчуудын соёлын хөгжилтийн улбаанаас ажиглахад монгол хүний газар нутгийн тухай ойлголт ба эзэмшлийн арга нь нутаг билчээр (газар дэлхий)-ийг байгалийн маягаар нь хүртэн ашиглах хөдөлгөөнт хэлбэр (нүүдэл буудал)-ээр урт удаан хугацаанд явагдаж хожим нь 17-р зууны үед манжийн түрэмгийллээс болж, тогтоолт нутгийг эрхшээн эзэгнэх болсон байв.

Хөдөлгөөнт (нүүдэл) загварт үйлдвэрлэлийн арга маяг нь байгалийн нутаг дэвсгэрийг бүрмөсөн талхих, ганц нэг орчин тойронд удаан хугацаанд амьдрах зэрэг амьдрал ахуйн дан ганц шинжийг огоорч чаддаг дэвшилт талтай боловч орон суцны тогтворт шинж орхигдож, хааяа зарим нутагт тун ахархан хугацаанд нутагладагаас хүн ба нутаг усны идээшин нэвчих онцлог шинж үгүй болж хүн зоны ер нь нүүдэл буудлын төлөөх байнгын хөөцөлдөөнд автуулдаг эмзэг талтай ч байдаг. Гэтэл талх тарианы ажлаар хөөцөлддөг тариачин үндэстэн бол тийм биш. Тэд монголчуудтай адил байгаль дэлхийн цаг улирлыг түшиглэж тариалан эрхэлдэг боловч нэгэнт тариалж нутагшсан орон нутгийнхаа эргэн тойронд жил турш тогтвортойгоор тариалан үйлдвэрлэдэг. Тийм болохоор тариачин үндэстний газар эзэмшил нь харьцангуйгаар нэлээд

тогтвортой, газар шорооны их баялгийг хүний хүчээр нээн ашиглахаар зорин үйлддэгээрээ нүүдэлчин үндэстэний аж амьдралаас гоц ялгаатай. Багцаалбал, газар нутгийг эзэгнэн эзэмших ухамсар, арга эвсэлийнхээ хэр хэмжээ, далайц нь тухайн тэр үндэстэний орон сууц (гэр орон) ба түүнтэй шууд холбогдсон бодисын үйлдвэрлэлийн арга техник жич түүний үр дүнг тогтоож байдаг. Монголчуудын нүүдлийн мал аж ахуй нь овгийн байгууллын үеэс нийтийн он тооллын 17-р зууныг хүртэл чөлөөт нүүдлийн байдалд оршиж байснаасаа Манж Чингийн "хошуу чуулганы дүрэм"-д чөдөрлөгдөн хумигдаж, зөвхөн тогтоолт нутагт суурьшин малжих буюу нутаг сэлгэж нүүн төдийгөөр хязгаарлагдах болжээ.

### **Хоёр. Монгол гэр ба хорчин соёлын шүтэлцээ холбоо**

Монгол гэр бол монгол соёлын дулаан елгий мөн. Олон зуу мянган жилийн турш дахь монголчуудын бүхий л эд өлгийн соёл нь эцсийн мөртөө бүр монгол гэрийн бөмбөргөн зайд түрэгдэн гарч хүмүүжигдэн дэлгэрсэн байдаг.

Монгол гэрийн соёл нь монголын өндөрлөгт аж төрөн амьдарч ирсэн бүхий л нүүдэлчин овог гүрний орон сууцны соёлыг цөм хамран багтаасан туйлын өнөр, баян утга агуулагдахуунтай байдаг. Өөрөөр хэлбэл монголын өндөрлөгийн буурал хөрсөнд ул мөрөө гүн гүнзгий үлдээж байсан Хүннү, Сяньби, Рүран, Түрэг, Уйгур, Хидан зэрэг угсаатан ястан монголын өндөрлөгийн нүүдэл мал аж ахуйн соёлыг хамтаараа үүдэн бүтээлцэж, монгол гэрийн соёлын баян санд өөр өөрийн нэмэр хандиваа өргөсөн байдаг.

Монголын өндөрлөгийн эртний нүүдэлчин овог аймгийн түүхт Төв Азийн нүүдэлчин үндэстний анхны том гүрнийг цогцлуулсан Хүннүчүүдийн гэрийг "Баруун Хан улсын түүх"-ийн 94-р бүлэгт "Бөмбөгөр хэлбэртэй эсгий сууц" гэж бүдүүвч тэмдэглэсэн бол монгол улсын заншил ухааныг судлагч Т.Майдар, Лха.Дарьсүрэн нар "Монгол гэр" гэх зохиолдоо "Манай эриний өмнөх гурван мянган жилийн тэртээх малчин аймгуудын амьдарч байсан ханат гэрийн хэлбэр ямар болохыг илэрхийлж чадах баримт бол Хүннү нарын гэр юм". "Эртний Хятадын түүхийн мэдээ, Европын эрдэмтдийн судалгааны баримтаар бол Хүннү нар малтмал газар сууц өрк, мөн тэргэт сууц, ханат гэрийг хэрэглэж байсан нь тодорхой билээ"<sup>11</sup> гэж нягтлан тоочихыг хичээжээ.

Хүннүгийн үед төмөрлөг багаж зэвсэг хэрэглэх болсоны зэрэгцээ гар үйлдвэрлэгчидийн эгнээнд хөдөлмөрийн хуваарь гарч "модон дархан", "төмрийн дархан", "алт мөнгөний дархан" буй болж онцгойлон модны дархан нь гэр тэрэгний мод ба бусад эдлэл хэрэгсэлүүдийг тусгайлан хийдэг байжээ. Гэхдээ монголын өндөрлөгт хүннүчүүдийн эд оюуны соёлыг өвлөн залгамжилсан аймаг гүрнүүдээс Рүранчүүдийг онц дурдалтай. Учир нь "Рүранчүүд дээшээгээ Хүннү, Сяньбийн орон сууцны соёлыг өвлөн залгамжилж, доошоо Түрэг, Хидан, Монголд уламжилснаас нэгэн бүрэн төгс монгол гэрийн соёлыг эхлэн бүрэлдүүлсэн байна"<sup>12</sup>. Хожим нь 13-р зууны үед хүрээд Монголын эзэнт төрийн үүсэл мандалыг дагалдан "Жинхэнэ монгол гэрийн соёл"-ын агуулга хэлбэр бүрэлдэн тогтож, 17-р зуунаас хойш улам улмаар өргөжин дэлгэрсэн байжээ.

Монгол гэр нь хөгжөөд умард Юан улсын үед хүрээд доорхи мэт хэдэн зүйлийн хувиралт хөгжилттэй болжээ.

**"Нэгд**, уулын байсан нүсэр хүнд хүзүүвчин тоонотой гэр аажмаар хаягдаж, хөнгөн авсаархан хүрдэн тоонотой гэр дэлгэрсэн байна.

**Хоёрт**, уулын байсан нүүдлийн том ордууд аажмаар хаягдаж, суурьшил орд харш ба хот балгас ихээр байгуулагдсан байна.

**Гуравт**, Монгол оронд шарын шашин хүчтэй дэлгэрснээс хүрээ хийд олноор байгуулагдаж, айл өрх бүрийн гэрт бурхан тахих болж, бөө мөргөлийн шашин бууралд орсон байна.

**Дөрөвт**, говийн өмнө захаар хятад айл улмаар олшрохыг дагалдан зарим монгол айл ч шавар тоосгоор барьсан гэрт суух болсон байна. Гэвч их говийн ар өвөр дэх ус өвс сайтай уудам саруул нутагт байгаа малчид мөн л уламжилалт нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлж, эсгий цагаан монгол гэртээ сууж, аж төрөн амьдарч байжээ"<sup>13</sup>.

16-р зууны сүүлчээр монголчууд манжийн ноёрхолд орж, Чин улсын засгаас хошуу нутгийн хил хязгаарыг чанга тогтоон, хил зааг давж нүүдэллэн малжихыг хориглосоноос монгол үндэстний "Мянга түмэн газар"-ын хэмжээнд нүүдэллэж зорчсон "их аялал", "их нүүдэл"-ийн цаг үе нэгэнт түүхийн шувтаргадаа орсон байжээ. Тэгээд тухайн эл хошуу чуулган ба найман хошууны монголчууд зөвхөн өөрсдийн хамаа бүхий хошуу чуулганы нутагтаа улиралыг даган нүүдэллэн амьдрах болсоноор уламжлалт гэр-тэрэг мэтийн нүсэр хүнд орон сууцны зүйл аяндаа орхигдож, суурьшин амьдрахад зохилдсон орон гэр улмаар хөгжин дэлгэрчээ.

"Эрх мөнгөтэй ван гүн тайж тавнан нар суух орд, бурхан гэр, шүүсний гэр, зочин хүлээн уулзах гэр, хөгжимчдийн гэр, бөхийн гэр ... мэт олон арван үүрэг зорилготой гэрүүдийг эдэлж байв"<sup>14</sup>.

Түүх тэмдэглэлээс ажиглавал хорчинчууд 16-р зууны дунджаар Нон мөрний урсгал дагуу орноос урагшилж дээд Шар мөрний урсгал дагуу оронд суурьшин нутаглахдаа шууд байшин гэрээр суурьшин амьдарсан биш, тухайн үеийн суурьшил малжил буюу хагас малжиж, хагас тариалах амьдралд тохирсон монгол гэр буюу өвөн гэр, бөргөө гэр мэтийн барьж буулгахад дөхөм авсаар бургасан гэрт суудаг байжээ.

Өвөн гэрийг "бэрхийн онгилоор ганц хоёроор суудаг" айл зөндөө хэрэглэдэг байв. "Өвөн гэрийг ганц хоёр хүн бүр барьчихдаг. Хүн амын олон цөөнд үндэслэж, нэг хоёр буюу цаашлаад гурав дөрвөн өвөн гэр барьдаг ч буй"<sup>15</sup>.

Өвөн гэрийн хамгийн том нь 1,6 хос алдаас хэтрэхгүй. Гэрийнхээ гол дунд нь нэг тулгуур зоодог бөгөөд нэг хос алд өвөн гэрийн дотоод эзэлхүүн нь бараг 6-7 тохой л байдаг.

Хожим нь байшин гэр олшрохыг дагалдан хүмүүс өвөн гэрт суухаа больсон бөгөөд гол гэр (байшин гэр)-ийнхээ зүүн буюу зүүн өмнө хавиар 1-2 хос алдын зайд өвөн гэр гэж бариад тусгайлан будаа тариагаа хийдэг.

Өвөн гэрийн хана нь бургасаар сүлжиж хийдэг болохоор хулгана үүрлэх газаргүй байдагаас будаа тариа хадгалахад тохирсон байдаг.

Бөргөө гэрийг үйлдэж бүтээх нь өвөн гэрийнхтэй үндсэндээ адил. Гэвч бөргөө гэрийн хаяа ба дээврийг нийтэд нь бургасаар сүлжиж, оройд нь тооно гэж 5 тохой нүх үлдээж тэр нь дөрвөлжин ба дугуй хэдэн янзын

хэлбэртэй байдаг. Энэ шинжээс нь уламжилж бид хорчины бөргөө гэрийг манай үндэсний уламжилалт монгол гэрийн нэг ёсны уламжлал шинэчлэлийн бодит гэрч гэж болмоор юм.

Ерийн бөргөө гэрийг сүлжиж хийхдээ шар бургас 70 боож (5-6 төөгийн боож) хэрэгсдэг. Бөргөө гэрийг хучихад хулс 300 боож (3 төөгийн боож) хэрэглэнэ. Шаваасын зузаан нь 3-4 хуруу цаашлаад сөөм зузаан шавах ч бий. Гадна дотноос нь сайтар шавсан, уяа (уны), тооно нь аятай сайн зохирсон бөргөө гэр 20-30 жил хэрэглэгддэг гэдэг. Хорчины өвөн гэр ба бөргөө гэр нь бүр л бургасаар сүлжиж хийдэг болохоор ерөнхийд нь бүр бургасан гэр гэж нэрлэдэг.

Алдарт эрдэмтэн Лувсанчойдонгоос монгол хүний орон сууцны соёлын эх сурвалжийг мөрдөн шинжлэхдээ: "Монголчуудын өвөг дээдэс хамгийн анхны орон сууцаа барьж эхлэхдээ овоохойн унинуудыг бат бэх тогтоох аргыг мэдэхгүй байсан тул ... амьд модыг багана болгож гол хийж, улалжин өвсөөр тойрон бүрхэж суумуй. Хойно хүн амьтан улмаар мэдэл нээгдэж уулын хажуу буюу канка (ганга) хийж өндөр газар оронд нүх ухаж гэр хийж суулцвай. Түүнээс Шарамба хэмээн биеийн хэвээр эхлэн модоор элдэв янзтай бөргөө гэр хийж суусаар улам хүний ухаан сэргэж урлан бөргөө гэрийг үүдэж хийсэн нэртэн хүнийг олон хүн үзээд гайхалдан гоёвчлон дархан хэмээн дуудмой"<sup>16</sup> гэж зөв зүйтэйгээр магадлан өгүүлжээ. Тэрхүү овоохой гэр буюу "шарамба" (Лувсанчойдоны үг) хэмээх бөргөө гэр нь их төлөв бөмбөгөр буюу шовгор хоёр янзын хэлбэртэй байж, энэхүү нүүж буухад дөхөм хялбар, босгох барихад тогтвортой овоохой гэр нь хэрэг дээрээ ханагүй монгол гэрийн маягтай урц байжээ. Тэр тусмаа овоохой гэр нь газар дээр барьдаг модон гэрийн эх үүсвэр болсноор барахгүй хожим нь бүр бөмбөгөр хэлбэртэй овоохойноос тэргэт гэр буюу гэрлэг болтлоо хөгжжээ. Учир нь орчин үе болтлоо Өвөр монголын Алшаад "Цээж гэр", Сөнөдөд "Довон гэр" буюу "Овоохой гэр", Ордост "Шалан гэр", Хорчинд "Бөргөө гэр" гэх мэтээр нэрлэгдэн хэрэглэгдсээр ирсэн тэдгээр олон орон сууцнууд нь үнэндээ язгуур эртний үеийн овоохой гэрийн нэг ёсны үлдэгдэл мөн.

Ер нь бургасан гэр гэдгийн тухай П.Дугарын "Монгол гэрийн соёл" гэх номд "Энэ бол орчин үе болтол хэрэглэгдэж байсан бургас буюу нарийн дэлдээр сүлжиж, дотор гадуур нь үхрийн баас буюу шавраар шавсан /бөмбөгөн гэр/ бололтой. Учир нь Тэмүжин гурван Мэргидийн аюулаас зайлж Бурхан Халдун уулнаа гарч түр сууж байсан нь бургасан гэр болох тул тийм тогтсон хэлбэр хийц гэж үгүй юм"<sup>17</sup> гэж тэмдэглэсэн байна.

Үүнээс үзвэл бургасан гэр нь монгол үндэстэний орон сууцны түүхэнд нэлээд эрт үед буй болж орчин үе болтлоо хэрэглэгдэж байсан орон гэрийн нэг онцгой хэлбэр байсан гэж болно. Энэ тухай Ордосын "Шалан гэр" буюу Сөнөдийн "бүнхэр гэр" зэргээр жишээлж болно.

Чин улсын Бадруулт төрийн сүүлчээс эхлэн Ордосчуудын амьдралын хэлбэрт ихээхэн хувиралт гарч, эндэх хүмүүс үндсэндээ суурьшсан ба Үшин хошуу, Отог хошуу, Засаг хошуу зэрэг бургас мод элбэг ургадаг газруудад "Шалан гэр" гэдэг шинэ хэлбэрийн гэр буй болов. Шалан гэрийн шалыг бургас модоор сүлжиж гадуур нь шавраар шавдаг боловч хэлбэр дүрсийнхээ хувьд монгол гэртэй их л төстэй байсан гэдэг. "Шалан дэрээ гэрийн униа тааруулан тогтоож орой дээр нь тооноо угсруулдаг. Гэрийн унийн гадуур нь эсгийгээр бүрж түүний гадуур нь бас

усан хулсыг тоонотой нь тулгаж дэлгэн бүрхэж модоор хавчиж уядаг. Хамгийн сүүлд нь эсгий өрхөө тооно дээрээ тааруулчихвал шалан гэр болчихдог. Шалан гэрийн дотор шабраар халуун ханз хийж тохируулдаг. Ийм гэрийг нүүлгэж болдоггүй, өөр сууринд нүүвэл тэнд дахин шинэ шалан гэрээ барьдаг. Ордос хүн ийм гэрээ /шалан гэр/ гэж, угийн монгол гэрээ /ханан гэр/ гэдэг<sup>18</sup>. Энд онцлон тэмдэглэхэд Ордосчуудын шалан гэр нь уриа эсгийгээр бүрэх, тооно дээрээ эсгий өрх тавих зэрэг тун ялимгүй зүйлээс бусад бүхий л эд, хэлбэр дүрс, хэрэгцээ үйлдэл зэрэг нь Хорчины бөргөө гэртэй эгээ адилхан байдгаараа маш сонирхолтой байна.

Ордосын шалан гэр ба Хорчины бөргөө гэртэй адилаар Сөнөдүүд ч "бүнхэр гэр" гэдэг бургасан гэрт суудаг байжээ. "Манай Сөнөдийн өмнө зах болох элсэн газраа нутагладаг айлууд бургасаар монгол гэрийн хэлбэртэй сүлжиж хийсэн бүнхэр гэр гэж байдаг бөгөөд түүний их бага нь адилгүй. Бүнхэр гэрийг шавар буюу үхрийн баасаар шавж нялдаг. Ийм гэр бол монгол гэртэй адилхан үүдтэй бөгөөд хүн сууж, отор нүүдэлд явахдаа үргэлж хэрэглэдэг. Гэвч, Сөнөдийн хойд бие, дунд биеэр хэрэглэхгүй байдаг"<sup>19</sup>.

Дээрх жишээ баримтуудаас үзвэл бургасан гэр нь нэлээд эрт үед суурьшил амьдралд шилжсэн элс манхан нутагт амьдардаг Хорчин, Ордос мэтийн монголчуудын гэр сууцанд хэрэглэгдэж байгаад хожим нь суурьшил амьдралын өргөжилт ба байшин гэрийн олшрохыг дагалдан орхигдсан байжээ. Иймээс бид бургасан гэрийг Хорчинчуудын нүүдлээс суурьшил амьдралд шилжих шилжилтийн үеийн орон сууцны нэг хэлбэр, монгол гэрийн Хорчин нутаг дахь ондоошил төрх гэж үзэх бүрэн үндэстэй байна.

#### Ашигласан ном

1. 2. 3. 4 Хүрэлшээ Бай-Цү-Ин. Начин. Буянчуглаа, "Хорчин бөө мөргөлийн судлал" Бээжин, Үндэсний хэвлэлийн хороо, 1998 он, 20-22-р тал
5. 8. 9 Д.Гонгор (Монгол) "Халх товчоо" (дэд дэвтэр), Бээжин, Үндэсний хэвлэлийн хороо, 1991 он, 487, 533-534-р тал
6. 7. 10 Готоо Томио (Япон) "Монголын отор нүүдлийн нийгэм" Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1990 он, 127, 131, 151-152-р тал
- 11 Галиндар "Монгол гэрийн уламжлалт ёсон" Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1990 он, 15-16-р тал
- 12, 13, 14, 15, 16, 17 П.Дугар нар "Монгол гэрийн соёл" Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1996 он, 45, 98, 109, 28-29, 60, 94-р тал
- 15 Хүрэлбаатар. Уранчимэг "Хорчины зан ааль" Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1988 он, 51-р тал
- 18 Са.Нарсан "Ордосын зан ааль" Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1989 он, 356-р тал
- 19 Д.Цагаан "Сөнөдийн зан ааль" Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1991 он, 2-р тал.